

ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН БҮТЭЦ

(19-р Зүйл: Дэлхий нийтээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхийн төлөөх байгууллага

ГАРЧИГ

УДИРТГАЛ

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ТОДОРХОЙЛОЛТУУД БА ЗОРИЛГО

Зүйл

1. Тодорхойлолтууд
2. Зорилго

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ҮҮСГЭН БАЙГУУЛАЛТ БА ГОЛЧЛОХ ЗАРЧИМУУД

3. Үүсгэн байгуулалт
4. Голчлох зарчимууд

ГУРАВДУГААР ХЭСЭГ: БҮТЭЦ

5. Захирлуудын зөвлөл
6. Захирлуудын зөвлөлийг томилох
7. Гишүүдийн хараат бус байдал
8. Томилолтын хугацаа
9. Захирлуудын зөвлөлийн цалин урамшуулалт
10. Захирлуудын зөвлөлийн үүрэг
11. Гүйцэтгэх захирлыг томилох
12. Процедурын журам
13. Ажилтан сонгон шалгаруулах, ажилд авах

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: ҮЙЛЧИЛГЭЭ

14. Агаараар дамжуулах хөтөлбөр
15. Нэмэгдэл хөтөлбөрийн үйлчилгээ
16. Бусад үйлчилгээ

ТАВДУГААР ХЭСЭГ: САНХҮҮЖИЛТ

17. Санхүүжилтийн механизмууд
18. Олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамж
19. Төсвийн шууд хөнгөлөлт
20. Зар сурталчилгаа
21. Ивээн тэтгэлэг

ЗУРГАДУГААР ХЭСЭГ: ХАРИУЦЛАГА

22. Жилийн тайлан
23. Олон нийтийн үнэлгээ
24. Гомдол хянан шийдвэрлэх журам

ДОЛДУГААР ХЭСЭГ: БУСАД

25. Зохиогчийн эрх
26. Архив
27. Улс төрийн сурталчилгаа

НАЙМДУГААР ХЭСЭГ: ШИЛЖИЛТИЙН БА ЭЦСИЙН ЖУРАМ

28. Мөрдөгдөж буй хууль, тогтоомж
29. Захиргааны асуудал
30. Хуулийн богино нэр ба хууль хүчин төгөлдөр болох

УДИРТГАЛ

Хэдэн анхаарууштай тохиолдлыг эс тооцвол дэлхийн ихэнх орнууд олон нийтийн санхүүжилт хяналтын дор үйл ажиллагаагаа явуулдаг **үндэсний телевиз, радиогийн байгууллагатай** байдаг. Эдгээр олон нийтийн өргөн нэвтрүүлэг байгууллага нь олон төрлийн мэдээлэл, үзэл бодлыг мэдэх олон нийтийн эрхийг хангахад, мөн мэдээллэл, үзэл бодлын чөлөөт урсгалыг бүрдүүлэх чухал үүрэг гүйцэтгэж чаддаг байна. Хэдий тийм ч, ихэнх орнуудад эдгээр үндэсний олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагууд олон нийтийн эрх ашгийн индэр байхаасаа илүү төрийн хяналтад байдаг тул засгийн газрын дуу хоолой болох нь олонтаа.

Олон улсын, үндэсний шүүхийн тогтоолууд, түүнчлэн гэрээ хэлэлцээр гэх мэт олон улсын засаглалын шинж чанар бүхий хууль эрхийн бусад хэлбэрүүдээс үзэхэд үзэл **бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний** олон улсын жишиг нь бүгд **олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагад** чухлаар нөлөөлөөлдөг. Эргэлзээгүй, эдгээрийн хамгийн ач холбогдолтой зүйл нь улс төрийн болоод арилжааны алив оролцоо байх ёсгүй гэсэн заалт буюу өөрөөр хэлбэл олон **нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага нь** хараат бус байх, агуулгын бие даасан байдлыг хүндлэх ёстой гэсэн заалт юм. Түүнчлэн, хөтөлбөрийн хувьд олон нийтийн **өргөн нэвтрүүлгийн байгууллага нь** ая тал зассан бус, тэнцвэрийг хадгалсан байх нь чухал. Хараат бус, шударга байдлын шаардлагыг хангасан тохиолдолд л телевиз радиог “олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага хэмээн тодорхойлно”.

Энэхүү **Олон Нийтийн Өргөн Нэвтрүүлгийн Хуулийн Бүтэц нь “Агаарын Долгионыг Хүртэх Боломжтой Байх: Үзэл Бодлоо Чөлөөтэй Илэрхийлэх Эрх Чөлөө болон Өргөн Нэвтрүүлгийн Зарчмууд ”** гэсэн 19-р зүйл байгууллагаас гаргасан ном болоод дэлхийн орнуудын олон нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын шилдэг хуулиудад тулгуурлан боловсруулсан **хуулийн бүтэц** юм.

“**Бүтэц**” гэсэн үгийг энд хэрэглсэн нь бүх оронд ийм тогтсон **бүтцээр** хуулиа боловсруулна, эсвэл энэхүү **бүтцэд** тусгалаа олсон зүйл бүр тухайн орны хуулинд орох ёстой гэсэн утгыг агуулаагүй. Орон бүр мэдээллийн харилцан адилгүй хэрэгцээ шаардлагатай ба өөр өөр бүтэц зохион байгуулалттай байдаг тул хуулийг тэрхүү шаардлагад нийцүүлэн боловсруулах ёстой. Жишээ нь, **энэхүү хуулийн бүтцэд** санхүүжилтийн үндсэн эх үүсвэр нь цахилгааны тооцоонд багтаасан татвар байгаа. Хэдийгээр энэ нь санхүүжих эх үүсвэрийн зонхилох хэлбэр болдог ч ялангуяа шилжилтийн орнуудад телевиз, радио бүрээс татвар авдаг нь ч хууль ёсны байж болно. “**Бүтэц**” гэсэн үг нь энд бичигдсэн зарчмуудыг тусгасан хуулиар олон нийтэд үйлчлэх хараат бус **өргөн нэвтрүүлгийн байгууллагыг** бий болгон, олон нийтийн ашгийн төлөө үйлчилж, мэдээллийн эрх чөлөөг хангана гэсэн санааг агуулж байгаа юм.

Олон Нийтийн Өргөн Нэвтрүүлгийн Хуулийн Бүтэц нь үндэсний хараат бус олон нийтийн өргөн нэвтрүүлгийг бий болгоно. Олон нийтийн **өргөн нэвтрүүлгийн байгууллага** нэвтрүүлбэл зохих хөтөлбөрийн чиглэлийг үүнд оруулсан байгаа ба бүх төрлийн үзэл бодол, үүднээс бичигдсэн мэдээллээр хөтөлбөрийг хангах зорилгоор бие даасан продюсеруудаас материал худалдаж авах тухай мөн багтаасан. Олон **нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллага нь** хэд хэдэн телевиз, радиогийн сувагтай байхаар заагдсан байгаа ба бусад холбогдолтой үйл ажиллагааг явуулах эрхтэй.

Бүтцийн хувьд парламентын доод танхимын (эсвэл адил эрх мэдэлтэй байгууллагаас) олон нийт, иргэний нийгмийн оролцоог хангасан, ил тод байдлаар томилсон Захирлуудын Зөвлөл олон **нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагыг** удирдана. Захирлуудын Зөвлөлийн хараат бус байдлыг хангасан хуулийн зүйл байх ба албан үүргээс нь тэднийг чөлөөлөх шалтгааныг хангаж өгсөн ч, тэдний томилолтын хугацаа хуулиар хамгаалагдсан байна. Түүнчлэн, хүчтэй улс төрийн холбоотой, эсвэл радио, телевизийн ашиг сонирхолтой хүмүүсийг Захирлуудын Зөвлөлд томилохыг хориглосон байна. Гуравны хоёр хувийн давамгайлсан саналаар Захирлуудын Зөвлөл Гүйцэтгэх Захирлыг томилох ба процедурынхаа дүрэм журмыг өөрсдөө тогтоох эрх мэдэлтэй байна.

Олон **нийтийн өргөн нэвтрүүлгийн байгууллагын** санхүүжилтийн гол эх үүсвэр нь иргэд байх буюу дээр дурьдсанчлан цахилгааны тооцоон дээр нэмж **олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний** хураамжаас бүрдэх ёстой. **Хуулийн бүтцийн** дагуу санхүүжилтийн бусад эх үүсвэр нь зар сурталчилгаа, ивээн тэтгэлэг мөн төсвийн шууд хөнгөлөлтийг хязгаарлагдмал байдлаар бүрдүүлнэ гэсэн заалттай байна.

Парламентын доод танхимд жилийн тайлан, аудитаар шалгагдсан дансны тооцоо өгснөөр олон нийтийн өмнө хариуцлага тооцох ба жилийн тайланд ямар агуулга багтах ёстойг мөн заажээ. Хэдий тийм ч, **хуулийн бүтцийн** дагуу олон нийтийн үнэлгээ байнга явуулахаар заасан ба байж болох гомдол шийдвэрлэх гадаад механизмаас гадна дотоод механизмыг бүрдүүлнэ гэжээ.

ОЛОН НИЙТИЙН ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН БҮТЭЦ

Чанартай олон нийтийн өргөн нэвтрүүлгийн тухай болон олон нийтийн эрх ашгийн төлөө мэдээллийн чөлөөт байдлыг хангах хууль.

Дараахь зүйлийг [Парламент гэх мэт хууль батлан гаргах эрх бүхий байгууллагын нэрийг оруулах] батласугай.

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: ТОДОРХОЙЛОЛТУУД БА ЗОРИЛГО

Тодорхойлолтууд

1. Нөхцөл өөрчлөгдөөгүй тохиодолд энэхүү хуулинд орсон нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно.

- (а) “зар сурталчилгаа” гэдэг нь мөнгө эсвэл адил төрлийн зүйлийн оронд нэвтрүүлэх цагаас сурталчлагчид өгсөн цаг ба бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээний худалдаа, арилжаа, түрээс сурталчилсан, эсвэл ямарваа нэг үзэл санааг дэлгэрүүлсэн, эсвэл сурталчлагчийн хүсч буй үр дүнд хүргэх бусад зүйлийг олон нийтэд зарлахыг;
- (б) “олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ” гэдэг нь олон нийт, олон нийтийн хэсэг бүлэг, эсвэл ийм үйлчилгээний хэрэглэгчдэд зориулсан дүрс, дуу бичлэгийг нэвтрүүлэн **дамжуулах** үйлчилгээг;
- (в) “нэвтрүүлгийн дүрэм” гэдэг нь хөтөлбөрийн агуулга болон олон нийтэд цацахад хамаарах жишиг стандартын цогцыг;
- (г) “бие даасан продюсер” гэдэг нь телевиз, радиогийн хөтөлбөр хийдэг, ямар нэг радио, телевизийн байгууллагад хамаардаггүй хувь хүн эсвэл компанийг;
- (д) “ястан үндэстэний/цөөнхийн хөтөлбөрийн үйлчилгээ” гэдэг нь олон нийтийн телевиз радиод байх мэдээллийн ба бусад **хөтөлбөрийг** тодорхой цөөнх эсвэл ястан үндэстэн өөрсдөө бэлтгэн, өөрсдийнхөө соёл, эрх ашгаа тусгасан, хөтөлбөрөө тэр хэлээр **дамжуулах** нэгжийг;
- (е) “хөтөлбөрийн хуваарь” гэдэг нь цацахаар төлөвлөгдсөн хөтөлбөрүүд, нэвтрүүлэх цаг хугацаа, зар сурталчилгаа, зорилтот бүлгийн хувиар гаргасан ерөнхий төлөвлөгөөг;
- (ё) “олон нийтийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хураамж” гэдэг нь олон нийтийн **өргөн нэвтрүүлгийг** санхүүгийн хувьд дэмжих цахилгааны тооцооноос авах хураамжийг;
- (ж) “ивээн тэтгэлэг” гэдэг нь телевиз радиогийн үйл ажиллагаа, дүрс, дуу бичлэгийн үйлдвэрлэлтэй холбогдолгүй хүн, эсвэл хуулийн этгээдийг хэлэх ба тэр хүний нэр, трейдмарк, дүр төрхийг сурталчлах зорилгоор шууд ба шууд бусаар хөтөлбөрийг санхүүжүүлэхийг хэлнэ.

ЗОРИЛГО

2. Энэ хуулийн зорилт нь:

- (а) олон нийтэд зориулсан өндөр чанартай телевиз, радиогийн хөтөлбөрийг дэмжих;
- (б) олон нийтэд хариуцлага тооцох ойлголтын хүрээнд олон нийтийн **өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ** үзүүлэгч **байгууллагыг** улс төр, арилжааны оролцооноос ангид байлган, олон нийтийн **өргөн нэвтрүүлгийн байгууллагын** хараат бус байдлыг хангах;
- (в) олон нийтийн **өргөн нэвтрүүлгийн байгууллагын** санхүүгийн тогтвортой байдлаар хангахад оршино.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: ҮҮСГЭН БАЙГУУЛАЛТ БА ГОЛЧЛОХ ЗАРЧИМУУД

Үүсгэн байгуулалт

3. (1) [Улсын нэрийг оруулах]-ын Өргөн Нэвтрүүлгийн Корпораци (буюу үүнээс хойш [улсын нэрийн эхний үсгийг оруулах, энэ хуульд Улсын **ӨНК**] **ӨНК**-г [хотын нэрийг оруулах, ихэнхдээ нийслэл хот] хотод байрлах, [улсын нэрийг оруулах] улсад бүхэлд нь үйлчлэх ашгийн бус олон нийтийн **өргөн нэвтрүүлгийн байгууллага** хэмээн байгуулсугай. **УӨНК** нь [парламентын (доод) танхимын буюу адил эрх мэдэл бүхий байгууллагын нэрийг оруулах]-д хариуцлага тооцон тайлагнах олон нийтийн байгууллага юм.
- (2) **УӨНК** нь үйл ажиллагааны болон захиргааны талаар ямарваа хүн, байгууллага, засгийн газар, засгийн газрын харъяа агентлагуудаас хараат бус байх ба ямар ч хүн, байгууллага хуулиар тодорхой заагдаагүй нөхцөлд **УӨНК** -ийн албан хаагч, гишүүд ажил үүргээ гүйцэтгэхэд нь нөлөө үзүүлэх, саад тотгор хийхийг хориглоно. Энэхүү хараат бус байдлыг ямагт хүндэтгэнэ.
- (3) **УӨНК** нь энэ хуулинд заагдсан үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай бүх шууд ба шууд бус эрх мэдлийг эдлэнэ. Тодорхойлбол, **УӨНК** нь хууль ёсны этгээд ба хөрөнгө бий болгох, эзэмших, өмчлөх, зарцуулах эрхтэй байна.

Голчлох Зарчимууд

4. (1) **УӨНК** нь [улсын нэрийг оруулах]-ын нутаг дэвсгэр даяар ястан үндэстэн, соёлын ба шашины ялгаатай байдлыг харгалзан үзсэн мэдээллийн, танин мэдэхүйн, хөгжөөх, [улсын нэрийг оруулах]-ын ард түмэнд үйлчлэх өргөн хөтөлбөр нэвтрүүлэн **дамжуулах** үүрэгтэй.

(2) **УӨНК** нь олон төрлийн үзэл санааг багтаасан, нийт ард түмний мэдээллийн шинж чанар бүхий нэвтрүүлгийн хэрэгцээ сонирхолыг хангасан, **хувийн өргөн нэвтрүүлгийн хөтөлбөр** дээр нэмэлт болсон шинэлэг, өндөр чанартай нэвтрүүлгүүд **дамжуулна**.

(3) Энэхүү олон нийтэд үйлчлэх **өргөн нэвтрүүлгийнхээ** үүргийг гүйцэлдүүлэх зорилгоор **УӨНК** нь:

(а) засгийн газар, улс төр, эдийн засгийн хяналтаас ангид, зөвхөн **УӨНК** -ын санал, үзэл санааг дангаар тусгаагүй, агуулгын мөн чанарыг тусгасан;

(б) оргил болон бусад цагт нийт хүмүүст сонирхолтой дотоодын болоод олон улсын бүрэн дүүрэн, дундыг баримталсан, тэнцвэртэй **мэдээний, цаг үеийн үйл явдлын** мэдээллийн хөтөлбөрүүдийг;

(в) соёлын өөр өөр байдлыг хүндэтгэн тусгасан ч [улсын нэрийг оруулах]үндэсний мөн чанарт нэмэрлэсэн;

(г) ястан үндэстэний/цөөнхийн хөтөлбөрийн үйлчилгээ болоод бусад нэвтрүүлгээрээ бүх үндэстэн ястны дуу хоолойг тэдгээрийн хэл дээр илэрхийлсэн [хамааралтай эсэхээс шалтгаалан энэ зүйлийг оруулах];

(д) нийтэд хамаарах болоод ялгавартай бүлэг хүмүүсийн хэрэгцээг хангасан нарийн мэргэжлийн **хөтөлбөр** хоорондох тэнцвэрийг хадгалсан;

(е) [парламентын дээд доод танхимын нэрийг оруулах] болоод голлох төрийн шийдвэр гаргагч байгууллагуудын үйл ажиллагааг хангалттай хэмжээнд үзүүлсэн;

(ё) өөр өөр бүс нутагт хамаарах хөтөлбөрүүд орсон;

(ж) олон нийтэд хамаарах чухал зар, зарлалыг хангалттай хэмжээнд **дамжуулсан**;

(з) боловсролын хөтөлбөрүүд болон хүүхдэд зориулсан хөтөлбөрүүдийг багтаасан;

(и) [улсын нэрийг оруулах]-д хөтөлбөр, нэвтрүүлэг хийхийг дэмжсэн;

(й) гэгээрсэн хэлэлцүүлэг, шүүмжлэлт сэтгэхүйд нэмэрлэсэн

өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ үзүүлнэ.

(4) [улсын нэрийг оруулах]-д хөтөлбөр, нэвтрүүлэг хийхийг дэмжих, түүнчлэн тал бүрийн санал, үзэл бодлыг тусгасан байдлыг хангах зорилгоор **УӨНК** нь нийт хөтөлбөрийнхөө 20 хувийг [улсын нэрийг оруулах]-д байршилтай бие даасан продюсеруудаас авахад зорино.

ГУРАВДУГААР ХЭСЭГ: БҮТЭЦ

Захирлуудын Зөвлөл

5. (1) Захирлуудын Зөвлөл [үүнээс хойш “Зөвлөл”] **УӨНК** -ийг удирдах ба **УӨНК** -ийн ил тод байх хариуцлага нь тэдний гол үүрэг байна. Үүнийгээ [парламентын (доод танхимын) нэрийг оруулах]-аар дамжуулан [улсын нэрийг оруулах]-ын нийт иргэдэд тооцно.

(2) Зөвлөл нь телевиз, радиогийн **байгууллага**, бодлого боловсруулалт, хууль, технологи, сэтгүүлзүй ба бизнесийн салбаруудад боловсрол, туршлага эзэмшсэн есөн (9) гишүүдээс бүрдэнэ.

Зөвлөлийг Томилох

6. (1) Дараахь журмын дагуу [паламентын (доод) танхимын нэрийг оруулах] нь Зөвлөлийн гишүүдийг томилно:

(а) томилох үйл явц нь нээлттэй ба ил тод байна;

(б) телевиз, радиогийн сонирхол бүхий иргэний нийгмийн байгууллагууд [парламентын (доод) танхимын нэрийг оруулах]-д Зөвлөлд өөрсдийн хүмүүсийн нэрийг дэвшүүлэх бодит боломжийг эдлэнэ;

(в) нэр дэвшигчдийн эцсийн байдлын жагсаалтыг урьдчилан хэвлэж, олон нийтэд түгээснээр эдгээр нэр дэвшигчдийн талаар олон нийт төлөөлөл хийх боломжийг хангана;

(г) Зөвлөлийн гишүүнчлэл нь [улсын нэрийг оруулах]-ын нийгмийн бүх бүлгийг төлөөлнө.

(2) Дараахь нөхцөлд:

(а) төрийн болон засгийн газрын ямарваа байгууллагад алба хаагч байвал;

(б) улс төрийн албан тушаалтан буюу улс төрийн намын гишүүн байвал;

(в) засгийн газрын аль ч түвшинд сонгуулийн албан тушаалтан байвал;

(г) телевиз, радио, холбоо харилцааны аливаа байгууллагын ажилтан, телевиз, радио, холбоо харилцааны аливаа байгууллагаас цалин авдаг, эсвэл телевиз,

радио, холбоо харилцааны аливаа байгууллагын шууд ба шууд бус санхүүгийн ашиг сонирхолтой байвал;
(д) олон улсын **эрх зүйгээр** хүлээн зөвшөөрөгдсөн зарчим журмын дагуу хүчирхийллийн гэмт хэрэг, эсвэл залилан мэхлэх, хулгайн гэмт хэргээр яллагдаж, тэр хэргийнхээ төлөө өршөөгдөөгүй, ял эдлэснээс хойш таван жил өнгөрөөгүй байвал Зөвлөлийн гишүүнээр томилогүй.

(2)(в) зүйлийн дагуу нэр дэвшигч хүмүүс Зөвлөлд томилогдох нь бололцоогүй байвал тэр саадаа арилгахад хэрэгцээтэй зүйл хийх боломжийг тэдэнд олгоно.

Гишүүдийн Хараат Бус Байдал

7. (1) Зөвлөлийн бүх гишүүд ажил үүргээ гүйцэтгэхдээ хараат бус, шударга байх ба дөрөвдүгээр хэсэгт заагдсан Голчлох Зарчмуудыг биелүүлэхэд анхаарна.
(2) Зөвлөлийн гишүүд хуульд заасан зүйлээс гадна ямарваа төрийн байгууллагаас ажил үүрэг гүйцэтгэлийнхээ талаар зааварчилгаа эрэхгүй ба зааварчилгааг хүлээж авахгүй.
(3) Зөвлөлийн гишүүд өөрсдийн томилогдсон албан тушаалаа зөвхөн **УӨНК**-д зориулах ба өөрийн болон хэн нэгэн этгээд болон байгууллагын хонжоо болгон ашиглахгүй.

Томилолтын Хугацаа

8. (1) Зөвлөлийн гишүүд зургаан (6) жилээр сонгогдох ба [парламентын (доод танхимын) нэрийг оруулах] нь эхний томилогдсон гишүүдээс Зөвлөлд ажиллах гурван (3) гишүүн хоёр (2) жилээр, өөр гурван (3) гишүүн нь дөрвөн (4) жилээр сонгогдох хүмүүсийг тодорхойлсон тохиолдолд л Зөвлөлийн гишүүдийг хоёр (2) дахь хугацаанд дахин сонгож ажиллуулж болно.
(2) [Парламентын (доод танхимын) нэрийг оруулах] нь Зөвлөлийн гишүүнийг дараахь нөхцөлд, сонсох процедурыг явуулсны дүнд ажил үүргээс нь чөлөөлөх шийдвэр гаргана:
(а) 5(4)-р зүйлд заасны дагуу Зөвлөлд томилогдох боломжгүй байвал;
(б) энэ хуульд, тэр дундаа Голчлох Зарчмын дөрөвдүгээр зүйлд заасан ажил үүргийн хариуцлагын талаар ноцтой зөрчил гаргасан;
(в) хүлээсэн үүргээ гүйцэтгэж чадахаа больсон;
(г) **хүндэтгэн үзэх** шалтгаангүйгээр Зөвлөлийн хурал дараалан гурван (3) удаа тасласан.

Зөвлөлийн Цалин Урамшуулал

9. (1) Зөвлөлийн гишүүд ажлынхаа төлөө цалин урамшуулал авахгүй.
(2) Зөвлөлийн гишүүд гишүүнийхээ үүргийг гүйцэтгэхтэй холбогдсон бодит зардал буюу аяллын, байрны, хоолны зардлаа нөхөн авна.

Зөвлөлийн Үүрэг

10. (1) Зөвлөл нь дотоод бодлого, бодлогын хэрэгжилт, Голчлох Зарчмын дөрөвдүгээр зүйлийн хэрэгжилт, **УӨНК**-ийн жишгийн өндөр түвшин дэх ажиллагаа, удирдах албан тушаалтныг, тэр дундаа Гүйцэтгэх Захирлыг томилох, мөн **УӨНК**-ийн голч стратегийг тодорхойлон хангах үүрэг хүлээнэ.
(2) Зөвлөл нь **УӨНК**-ийн өдөр тутмын удирдлагын үйл явц ба Гүйцэтгэх Захирал, түүний ажилтнуудын ажлын агуулгын хараат бус байдалд хөндлөнгөөс оролцохгүй.
(3) Гүйцэтгэх Захиралтай зөвлөлдсөний үндсэн дээр Зөвлөл нь **УӨНК**-ийн хууль дүрмийг батлана. Эдгээр хууль дүрэм нь энэ хууль болон холбогдох хууль, тогтоомжийн дагуу **УӨНК**-ийн бодлого, үйл ажиллагааны чиглэл, процедурыг тогтооно.
(4) Гүйцэтгэх Захиралтай зөвлөлдсөний үндсэн дээр Зөвлөл нь **УӨНК**-ийн Жилийн Тайлан ба Төсвийг гаргаж, [парламентын (доод танхимын) нэрийг оруулах]-д батлуулахаар оруулна.

Гүйцэтгэх Захирлыг Томилох

11. (1) Үүсгэн байгуулалтын дараа аль болох хурдан хугацаанд Зөвлөлийн гишүүдийн гуравны хоёрын давуу саналаар Гүйцэтгэх Захирлыг сонгон томилох ба адил саналын дагуу орлох хүнийг олсон тохиолдолд Гүйцэтгэх Захирлыг ажлаас нь чөлөөлнө.
(2) 6(2)-р зүйлд заасанчлан *mutatis mutandis* зарчмын дагуу Гүйцэтгэх Захиралд хамаарна.
(3) Гүйцэтгэх Захирлыг таван (5) жилээр томилох ба дахин сунгаж болно. Гүйцэтгэх Захирлын томилолтын хугацааны эцэст оронд нь томилох хүнийг олоогүй тохиолдолд шинэ Гүйцэтгэх Захирлыг томилтол албан тушаалдаа үлдэнэ.
(4) Гүйцэтгэх Захирал өдөр тутмын ажлыг удирдах хариуцлагыг үүрэх ба эрхлэгчидтэй хамтран агуулгын бодлогыг боловсруулна.

Процедурын Журам

12. (1) Зөвлөл нь Зөвлөлийн Тэргүүн, Дэд Тэргүүнийг сонгож, үүргээ гүйцэтгэн, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай уулзалт болон бусад үйл ажиллагааны журмыг тогтооно.
- (2) Зөвлөл нь хэрэгцээтэй гэж үзсэн үедээ хуралдах ба сардаа нэг удаа заавал хуралдана. Зөвлөлийн хурлыг Тэргүүн зарлан хуралдуулах ба гурваас (3) доошгүй Зөвлөлийн гишүүдийн хүсэлтээр мөн хурлыг зарлан хуралдуулна. Зөвлөлийн ирц таваас (5) доошгүй байсан тохиолдолд хүчин төгөлдөр байна.
- (3) Гүйцэтгэх Захирал нь Зөвлөл түүнийг оруулахгүй гэж тодорхой шийдээгүй тохиолдолд Зөвлөлийн хуралд санал өгөх эрхгүй гишүүнээр оролцож болно.
- (4) Хуралд ирсэн гишүүдийн дийлэнхийн саналаар Зөвлөл шийдвэр гаргах ба санал тэнцсэн тохиолдолд Тэргүүн шийдвэрлэх саналыг нэмнэ.

Ажилтан Сонгон Шалгаруулах, Ажилд Авах

13. (1) Гүйцэтгэх Захирал нь батлагдсан төсвийн дагуу шаардагдах ажилтнуудыг сонгон томилно.
- (2) Гүйцэтгэх Захирал ба ажилтнууд нь хуульд заасны дагуу Зөвлөл болон [парламентын (доод танхимын) нэрийг оруулах]-аас гадна ямарваа төрийн байгууллагаас ажил үүрэг гүйцэтгэлийнхээ талаар зааварчилгаа эрхгүй ба зааварчилгааг хүлээж авахгүй.
- (3) Гүйцэтгэх Захирал ба ажилтнууд нь өөрсдийн томилогдсон албан тушаалаа зөвхөн **ҮӨНК** -д зориулах ба өөрийн болон хэн нэгэн этгээд байгууллагын хонжоо болгон ашиглахгүй.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: ҮЙЛЧИЛГЭЭ

Агаараар Дамжуулах Хөтөлбөр

14. (1) **ҮӨНК** нь [холбогдох тоог оруулах] үнэгүй, агаараар **дамжуулагдах** телевизийн сувагтай, [холбогдох тоог оруулах] үнэгүй, агаараар **дамжуулагдах** радиогийн сувагтай байна.
- (2) **ҮӨНК** нь дээрх 1-р дэд зүйлийн дагуу нэвтрүүлэг **дамжуулах** үүргээ гүйцэтгэхийн тулд шаардлагатай **долгионы давтамжуудаар** хангагдана.

Нэмэлт Хөтөлбөрийн Үйлчилгээ

15. (1) **ҮӨНК** нь сансарын антенн, кабель, Интернет гэх мэт өөр техникийн тусламжтайгаар хөтөлбөрөө **дамжуулах** эрх эдлэнэ.
- (2) **ҮӨНК** нь [холбогдлоор нь хараат бус **өргөн нэвтрүүлгийн** зохицуулалтын газар эсвэл парламентын (доод) танхимын нэрийг оруулах]-аас зөвшөөрөл авсны үндсэн дээр нэмэлт сувгуудыг **дамжуулах** эрх эдлэнэ.

Бусад Үйлчилгээ

16. **ҮӨНК** нь ерөнхий зорилгоо гүйцэлдүүлэхтэй холбоотой, Голчлох Зарчмуудын дөрөвдүгээр зүйлтэй нийцсэн хэвлэл гаргах, дүрс бичлэг үйдвэрлэх, эсвэл телетекстын үйлчилгээ үзүүлэх гэх мэт бусад үйл ажиллагаа явуулж болно.

ТАВДУГААР ХЭСЭГ: САНХҮҮЖИЛТ

Санхүүжилтийн Механизмууд

17. (1) **ҮӨНК** нь олон нийтийн эх сурвалж буюу Олон **Нийтийн Өргөн Нэвтрүүлгийн Үйлчилгээний** Хураамж, төсвийн шууд хөнгөлөлт, зар сурталчилгаа, ивээн тэтгэлэг, хандив болон бусад арилжааны үйл ажиллагаанаас санхүүжиж болно.
- (2) **ҮӨНК** -ийн Зөвлөл нь Жилийн Тайлан ба гадны байгууллагаар аудитлагдсан санхүүгийн тооцоо дансны үлдэгдлийг ирэх жилийн төсвийн хамт [парламентын (доод) танхимын нэрийг оруулах]-д танилцуулан, батлуулахаар өргөн барина.

Олон Нийтийн Өргөн Нэвтрүүлгийн Үйлчилгээний Хураамж

18. (1) [Улсын нэрийг оруулах]-ын цахилгаан хэрэглэгч бүх айл, бизнес болон бусад байгууллагууд цахилгааны тооцоон дээр нь нэмэгдэх Олон Нийтийн **Өргөн Нэвтрүүлгийн Үйлчилгээний Хураамж** хэмээгдэх төлбөрийг төлнө.
- (2) **Олон Нийтийн Өргөн Нэвтрүүлгийн Үйлчилгээний Хураамжийн** түвшинг **ҮӨНК** нь [парламентын (доод) танхимын нэрийг оруулах]-д санал болгон, түүнийг нь [парламентын (доод) танхимын нэрийг оруулах] батлана. [Цахилгаан Эрчим Хүчний Корпорацийн нэрийг оруулах] нь УТРК болон [Цахилгаан Эрчим Хүчний Корпорацийн нэрийг оруулах]-ын хоёр талын байгуулах гэрээнд үндэслэн энэ хураамжийг цуглуулан **ҮӨНК** д шилжүүлнэ.

(3) Хураамжийг айл, бизнес нэгж бүрт тогтсон хэмжээгээр тогтоож болох ба эсвэл цахилгаан хэрэглэсний тодорхой хувийг тогтоож болно.

Төсвийн Шууд Хөнгөлөлт

19. (1) **УӨНК** -ийн батлагдсан төсөв нь шууд хөнгөлөлтийг багтаахаар заасан байвал үүнийг улсын төсвөөс төлнө.

(2) Төсвийн шууд хөнгөлөлтийн мөнгийг хөтөлбөр бэлтгэлийг санхүүжүүлэх бус харин дэд бүтэц, бусад техникийн зардлыг нөхөхөд ашиглана.

Зар Сурталчилгаа

20. (1) **УӨНК** нь дараахь нөхцөлийн дор буюу:

(а) **өргөн нэвтрүүлгийн** сурталчилгаа нь өдрийн хөтөлбөрийн 7.5 хувиас хэтрэхгүй, эсвэл тухайн нэвтрүүлэг, цагийн 10 хувиас хэтрэхгүй тохиолдолд;

(б) зар сурталчилгаа болон бусад арилжааны үйл ажиллагааны орлого нийт орлогын 25 хувиас дээшгүй байх тохиолдолд;

(в) **Олон Нийтийн Өргөн Нэвтрүүлгийн Үйлчилгээний Хураамж** болон бусад олон нийтийн санхүүжилтийг өөрийн зар сурталчилгаа, бусад арилжааны үйл ажиллагаагааг санхүүжүүлэх, шударга бусаар түгээн дэлгэрүүлэхгүй байх тохиолдолд

зар сурталчилгаа нэвтрүүлж болно.

(2) Бүх зар сурталчилгааг зар сурталчилгаа хэмээн тодорхойлно.

(3) Зар сурталчилгаа нь үнэн ба бодит байх ёстой буюу, хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн, эсвэл ашиг сонирхолд нь нөлөөлсөн байх ёсгүй.

(4) **УӨНК** нь янжуур болон тамхины төрөл, архи согтууруулах ундааны төрөл, зөвхөн эмчийн заавраар олгогдох эм тариа буюу хүүхдийн нүдэнд өртөж, хүүхдийг гэмтээж болох эм тариа эдгээр зүйлийг сурталчлахгүй.

Ивээн Тэтгэлэг

21. (1) Ивээн тэтгэлэгт нэвтрүүлгийн эхэн ба төгсгөлд ивээн тэтгэгчийг тодорхойлон, ивээн тэтгэлэгт нэвтрүүлэг гэдгийг тодорхой мэдээлнэ.

(2) Ивээн тэтгэлэг нь нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрийн цагийн хуваарьт ямарваа нөлөө үзүүлэхгүй.

(3) Мэдээлэл, **цаг үеийн** үйл явдлын нэвтрүүлгийг ивээн тэтгэхгүй.

ЗУРАВДУГААР ХЭСЭГ: ХАРИУЦЛАГА

Жилийн Тайлан

22. (1) **УӨНК** -ийн Зөвлөл нь Жилийн Тайлан ба гадны байгууллагаар аудитлагдсан санхүүгийн тайлан, дансны үлдэгдлийг хэвлэж, өргөнөөр түгээнэ. Жилийн Тайланд дараахь мэдээлэл багтана:

(а) өмнөх жилийн орлого, зарлагын ерөнхий тайлан ба аудитлагдсан дансны тооцоо;

(б) шууд ба шууд бусаар **УӨНК** -ийн бүрэн ба бүрэн бус өмчлөлд байдаг ямарваа компаний тухай мэдээлэл;

(в) ирэх жилийн төсвийн санал;

(г) санхүү ба захиргаатай холбогдолтой мэдээлэл;

(д) өмнөх жилийн **УӨНК** -ийн зорилтууд, тэдгээрийн хэрэгжилт, мөн ирэх жилийн зорилтууд;

(е) **УӨНК** -ийн агуулгын бодлого;

(ё) Зөвлөлийн гүйцэтгэсэн судалгаа;

(ж) **УӨНК** -ийн өмнөх жилийн үйл ажиллагааны тайлан;

(з) Хөтөлбөрийн Хуваарь болон Хуваарьт хийхээр төлөвлөгдөж буй өөрчлөлтүүд;

(и) **УӨНК** -ийн нэвтрүүлж цацсан бие даасан продюсер болон компаниудын нэвтрүүлгийн жагсаалт, болоод эдгээрийг хариуцан бүтээсэн бие даасан продюсер, компаниудын нэрсийн жагсаалт;

(й) олон **нийтийн өргөн нэвтрүүлгийн тухай** зөвлөмж;

(к) үзэгчдийн санал гомдлын тухай мэдээлэл.

Олон Нийтийн Үнэлгээ

23. Ил тод байдлыг хангах, мөн олон нийтийн эрх ашгийн төлөө үйлчилгээг сайжруулах зорилгоор **УӨНК** нь олон нийтийн эрх ашигт илүү сайн хүрч ажиллах боломжийн талаар нээлттэй уулзалт, семинар зохион байгуулснаар олон нийтийн үнэлгээ шалгалт байнга явагдах байдлыг хангана.

Гомдол Хянан Шийдвэрлэх Журам

24. (1) **УӨНК** нь гомдол **хянан шийдвэрлэх дотоод журам** болон биеэ авч явах байдлын журмыг тогтоож, түүнийхээ дагуу гомдолыг хянан шийдвэрлэнэ.
(2) Журам зөрчигдсөн хэмээн үзсэн тохиолдолд хувь хүмүүс **УӨНК** -д гомдол гаргаж болох ба ийм гомдлын дагуу **УӨНК** нь шударга, тэнцвэртэй байдлаар шийдвэрлэнэ.
(3) **УӨНК** -д гомдол мэдүүлэхээс гадна бусад арга замаар гомдлоо **хянан** шийдвэрлүүлж болно.
(4) Гомдол **хянан шийдвэрлэх журам** нь худлаа баримт, мэдээ цацсан байдлыг зүгшрүүлэн засах боломжийг олгоно.

ДОЛДУГААР ХЭСЭГ: БУСАД

Зохиогчийн Эрх

25. (1) **УӨНК** нь зөвхөн өөрсдийн бүтээсэн эсвэл нэвтрүүлэх эрхийг нь эзэмшдэг **хөтөлбөрүүдийг дамжуулна**.
(2) **Хөтөлбөр бүрдээ** зохиогчийн эрхийг тодорхой бичиж **дамжуулна**.

Архив

26. (1) **УӨНК** нь нэвтрүүлгээ **дамжуулсны** дараа доод тал нь хорин найман (28) хоног бүх хөтөлбөрийн мастер бичлэгийг хадгалах үүрэгтэй.
(2) Хэрэв ямарваа **нэвтрүүлсэн** материал дээр маргаан эсвэл гомдол үүссэн тохиолдолд **УӨНК** нь асуудлыг **эцэслэн** шийдвэрлэтэл тэдгээр материалыг хадгалах үүрэгтэй.
(3) **УӨНК** нь түүхэн үүднээс [улсын нэрийг оруулах]-ын хүмүүст сонирхолтой байх материалын нэвтрүүлгийн фонд бүрдүүлнэ.

Улс Төрийн Сурталчилгаа

27. [Сонгуулийн хууль эсвэл сонгуулийн хорооноос гаргасан сонгуулийн журамын нэрийг оруулах]-д зааснаас гадна **УӨНК** нь ямарваа нэг улс төрийн суудалд өрсөлдөж буй нам, нэр дэвшигчийн нэрийн өмнөөс, нам, нэр дэвшигчийн төлөө улс төрийн сурталчилгаа цацахгүй.

НАЙМДУГААР ХЭСЭГ: ШИЛЖИЛТИЙН БОЛОН ЭЦСИЙН ЖУРАМ

Мөрдөгдөж байгаа хууль тогтоомж

28. Тэр үед байсан телевиз, радиогийн хэрэгслэлийг зохицуулах хууль, байгууллагыг энэ хуулийн зүйлтэй зөрчилдөж, орлосон хэмээн хуульд **нэмэлт өөрчлөлт оруулж**, хуулийг хүчин төгөлдөр бус болгож, байгууллагыг татан буулгаагүй тохиолдолд энэ хууль хүчин төгөлдөр болсноор телевиз, радиогийн хэрэгслэлийг зохицуулагч хууль, байгууллагад нөлөөлөхгүй.

Захиргааны Асуудал

29. (1) Энэ хуулийн заалтын дагуу, хууль хүчин төгөлдөр үйлчлэх болсноос хойш зургаан (6) сарын дотор Зөвлөлийг томилно.
(2) Энэ хуульд заасан бусад захиргаа, байгууллагын зохицуулалтыг хууль хүчин төгөлдөр үйлчлэх болсноос хойш зургаан (6) сарын дотор гүйцэтгэнэ.

Хуулийн Богино Нэр ба Хууль Хүчин Төгөлдөр Болох

30. (1) Энэ хуулийн нэрийг цаашид [оныг оруулах]-ы Олон Нийтэд Үйлчлэх Телевиз, Радиогийн Хэрэгслэлийн Хууль хэмээнэ.
(2) Энэ хууль [хамаарах хувь хүн буюу ерөнхийлөгч, ерөнхий сайд, эсвэл сайдын нэрийг оруулах]-ий **батлагдсан** өдөр хүчин төгөлдөр болно. Хэрэв **батлагдсанаар** хүчин төгөлдөр болгохгүй бол хууль батлагдснаас хойш **шууд** зургаан (6) сарын дараа хүчин төгөлдөр болно. ◆